



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46а ш/х-460,  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 4,  
Утас/Факс: (976) 75754400-4101,  
E-mail: bs@num.edu.mn  
http://bs.num.edu.mn

ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДАД

2026.04.13 № 16/175

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Ш.Насанжаргалын нэрэмжит  
“Мэдлэгийн Менежмент” улсын X олимпиад  
зохион байгуулах тухай

Тус сургуулийн Менежментийн тэнхимээс бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын дунд 2012 оноос хойш “Мэдлэгийн менежмент”-ийн улсын олимпиадыг уламжлал болгон зохион байгуулж ирсэн.

Энэ жилийн буюу арав дахь удаагийн олимпиадаас эхлэн уг олимпиадыг Монгол улсад төлөвлөгч, стратегич мэргэжлийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, боловсронгуй болгох, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан профессор Шаравын Насанжаргалын нэрэмжит болгон зохион байгуулахаар МУИС-ийн Бизнесийн сургуулийн Захиргаа шийдвэрлэсэн.

Өмнөх олимпиадуудад бизнес, эдийн засгийн чиглэлээр сургалт явуулдаг дотоодын их, дээд сургуулиуд амжилттай оролцож ирсэн. Олимпиад нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн BSG (Business Strategy Game) онлайн симуляцид суурилан зохион байгуулагддаг.


Олимпиадын хүрээнд оролцогч оюутнууд бизнесийн удирдлагын онолын мэдлэгээ ашиглан бодит орчныг төлөөлүүлэн загварчилсан бизнесийн орчинд салбарын болон өрсөлдөөний шинжилгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, стратеги боловсруулах, эрсдэлийг тооцох, стратегийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх чиглэлээр стратегийн симуляц тоглоомд оролцон өрсөлдөнө.

Энэхүү олимпиад нь оролцогчдод академик сургалтын явцад эзэмшсэн онолын мэдлэгээ практикт хэрэглэх ур чадварыг хөгжүүлэх, өөрсдийгөө сорих, бусад багуудтай өрсөлдөх, чансаагаа харьцуулах боломжийг бүрдүүлдэг.

“Шаравын Насанжаргалын нэрэмжит Мэдлэгийн менежмент” улсын X олимпиад 2026 оны 05 дугаар сарын 09-ний өдөр (Бямба гариг) зохион байгуулагдах тул сургуулиасаа баг бүрдүүлж идэвхтэй оролцохыг урьж байна.

Хавсралт 5 хуудастай. Олимпиадын удирдамжийг хавсаргав.


ЗАХИРАЛ



Н.БАТНАСАН

1426070205

**“МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ”  
УЛСЫН Х ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**



**Нэг. Зорилго, ач холбогдол**

МУИС-ийн Бизнесийн сургуулийн Менежментийн тэнхимээс Бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын дунд 2012 оноос эхлэн “Мэдлэгийн менежмент”-ийн улсын олимпиадыг есөн удаа амжилттай зохион байгуулаад байна.

Энэ жилийн арав дахь удаагийн олимпиадаас эхлэн тус Мэдлэгийн менежмент олимпиадыг Монгол улсад төлөвлөгч болон стратегич мэргэжлийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, боловсронгуй болгох, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан, хамтран зүтгэгчид болон төгсөгчдийн хүндэтгэлийг хүлээсэн эрхэм профессор Шаравын Насанжаргалын нэрэмжит болгон зохион байгуулахаар МУИС-ийн Бизнесийн сургуулийн Захиргаа шийдвэрлэснийг дуулгахад таатай байна.

Тус олимпиадын хүрээнд оролцогчид нь их дээд сургуулийн бизнесийн удирдлагын хөтөлбөрөөр суралцах явцдаа олж авсан мэргэжлийн онолын мэдлэгтээ тулгуурлан бизнесийн практик кейс дээр стратегийн оновчтой шийдвэр гаргах ур чадвараараа өрсөлддөг.

Мэдлэгийн менежментийн олимпиад нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн BSG /Business Strategy Game/ гэсэн онлайн симуляцид суурилан явагддаг. BSG буюу Бизнесийн стратегийн тоглоом нь дэлхийн нэр хүндтэй их, дээд сургуулиудын бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрт суралцагчдын дунд илүү өргөн ашиглагддаг. Суралцагчид нь спорт гутал үйлдвэрлэлийн салбарыг загварчилсан орчинд өрсөлдөгч компаниудын удирдлагын багийн дүрд тоглон, тухайн компани ямар бүтээгдэхүүнийг ямар зах зээлд гаргах талаар шийдлүүдийг гаргана.

Энэхүү олимпиадад оролцсоноор салбарын болон өрсөлдөөний шинжилгээ хийх, байгууллагын бизнесийг зөв үнэлэх, бизнесийн түвшний болон функциональ түвшний стратегийг амжилттай боловсруулах, бизнесийн эрсдэлийг тооцох, стратегийг хөгжүүлэх ба дахин сайжруулах чиглэлээр бизнесийн бодит орчныг төлөөлүүлэн загварчилсан бизнесийн стратегийн онлайн тоглоомыг интернэтийн орчинд тоглож, хоорондоо өрсөлдөхийн зэрэгцээ дэлхийн бусад орны тоглогчидтой чансаагаа харьцуулан үзэх боломжтой.

**Хоёр. Олимпиадын хамрах хүрээ**

2.1. Бизнесийн удирдлагын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн багш, оюутнуудаас бүрдсэн баг оролцоно. Баг нь 1 удирдагч багш, 3 оюутны бүрэлдэхүүнтэй байна. Оюутан нь бакалаврын түвшинд суралцдаг байна. Гишүүдийн нэг нь багийн ахлагч байна.

**Гурав. Олимпиад явагдах зарчим**

3.1. Олимпиад олон улсад хүлээн зөвшөөрөгдөн BSG /Business Strategy Game/ программын дүрмээр явагдана;

3.2. Тоглоом онлайн орчинд англи хэл дээр явагдана;

3.3. Оролцогч багууд бизнесийн бодит орчныг төлөөлүүлэн загварчилсан салбар (industry)-т гарааны адил байр суурьтай байгаа тус бүр нэг компанийг төлөөлөн хоорондоо өрсөлдөж, өгөгдсөн бүсүүд дэх зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулна;

3.3 Удирдагч багш нь оюутнуудаа дасгалжуулж, оролцуулах үндсэн үүрэгтэй байх бөгөөд тоглолт (тоглолтын тоог зөвлөлдөх уулзалтаар шийдвэрлэнэ)-ын 2 болон 5 дахь үеийн шийдвэрүүдэд зөвлөгөө өгч болно. Бусад үед хөндлөнгөөс ажиглана;

3.4 Тоглолтын үр дүн программаар бодогдон гарч ирэх бөгөөд субъектив хүчин зүйлийн нөлөө орох боломжгүй байна.

### Дөрөв. Зохион байгуулалт

4.1. Оролцогч сургуулиудын удирдагч багш нарын зөвлөлдөх уулзалт 2026 оны 04-р сарын 24-ны Баасан гарагт 14.00 цагаас хичээлийн 4-р байрны 314 тоот өрөөнд болно.

Уулзалтаар туршилтын шийдвэрийн тоо, туршилт хийх хуваарь, мөн жинхэнэ тоглолтын шийдвэрийн тоо, шийдвэр оруулах хугацаа зэрэг асуудлыг хэлэлцэж тохирно;

4.2. Олимпиадын чиглүүлэх сургалт хийх хугацаа, байршлыг хэлэлцэж тогтоно.

Тоглолтыг эхлүүлэх, явцад хяналт тавих, чиглүүлэх, үр дүнг тэмдэглэж, байр эзлүүлэх үүрэг бүхий хөндлөнгийн модератор урилгаар ажиллана;

4.3. Жинхэнэ тоглолт болохоос 2-3 хоногийн өмнө оролцогчид өөр өөрсдийн сургууль дээрээ өгөгдсөн эрх, нууц үгийг ашиглан серверт хандаж өгөгдлөө оруулан туршилтын тоглолт хийж бэлтгэлээ хангана;

4.5. Олимпиад явагдах хугацаанд багийн гишүүд тодорхой сахилга баттай байж, гадагш гарах, сэлгүүцэх, бусдадаа саад учруулах зэрэг зохимжгүй үйлдэл гаргахгүйгээр шударга өрсөлдөх нь зүйтэй бөгөөд зохион байгуулагчдын зүгээс цай, кофе, үдийн хоолоор үйлчилнэ;

4.6. Олимпиадын жинхэнэ тоглолт МУИС-ийн хичээлийн 5-р байр, Бизнес төвийн 106 тоот өрөөнд 2026 оны 05 сарын 09-ны Бямба гарагийн 08.30 цагт эхэлнэ.

### Тав. Шагнал, урамшуулал

5.1. Тоглолтын үр дүнгээр дараах байруудыг шалгаруулж, өргөмжлөл, медаль /багийн бүх гишүүдэд/, мөнгөн шагнал олгоно. Үүнд:

I дүгээр байр:	1 баг, өргөмжлөл, Алтан медаль	1,200,000 (нэг сая, хоёр зуун мянган) төгрөг
II дугаар байр:	1 баг, өргөмжлөл, Мөнгөн медаль	900,000 (есөн зуун мянган) төгрөг
III дугаар байр:	1 баг, өргөмжлөл, Хүрэл медаль	600,000 (зургаан зуун мянга) төгрөг

5.2. Оролцсон бусад багийн гишүүдэд батламж гардуулна.

### Зургаа. Олимпиадад оролцогчдыг бүртгэх

6.1. Олимпиадад оролцох багуудын мэдүүлгийг 2026 оны 05-р сарын 01-ны 17.00 цаг хүртэл МУИС-ийн Бизнесийн сургуулийн 214 тоот өрөөнд ирж биечлэн бүртгүүлэх эсвэл [zulbayar@num.edu.mn](mailto:zulbayar@num.edu.mn) cc: [nsonintamir@num.edu.mn](mailto:nsonintamir@num.edu.mn) хаягаар /материалуудыг сканердаж/ илгээж болно. И-мэйлээр бүртгүүлсэн тохиолдолд холбогдох утсаар заавал мэдэгдэх ба эх материалуудыг Олимпиадын чиглүүлэх сургалтад ирэхдээ авчирч, мандатаа хүлээн авна;

6.2. Олимпиадад бүртгүүлэхэд дараах материалуудыг бүрдүүлж, хавсаргана. Үүнд:

- Оролцогч багийн мэдүүлгийг (Хавсралт 1)-д заасны дагуу бичиж, сургуулийнхаа албан бланк дээр хэвлүүлэн баталгаажуулж ирэх. Энэ нь багийн гишүүдийг тус сургуулийг төлөөлөх эрх бүхий этгээд мөн гэдгийг нотлох үндсэн баримт болно;

- Удирдагч багшийн ажлын үнэмлэхийн хуулбар эсвэл үндсэн багш болохыг нотлох тодорхойлолт;

- Оюутны албан ёсны үнэмлэхийн хуулбар, анх сургуульд элссэн тушаалын хуулбарын хамт тус тус хавсаргана;


- Багийн гишүүдийн 1 хувь цээж зураг;

- Оролцогч багийн хураамж нь **500,000** /таван зуун мянга/ төгрөг байна. Хураамжийг олимпиадад оролцогч багууд **2026 оны 05-р сарын 01-ны** өдрийн дотор холбогдох дансанд байршуулсан байна.

Дансны мэдээлэл:

- МУИС Бизнесийн сургууль, ХААН банкны 5041123756 тоот данс

*Боловсруулсан: Улсын X олимпиадыг зохион байгуулах комисс*



1 дүгээр хавсралт

“ МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬД”

“Мэдлэгийн менежмент” улсын  
X олимпиадад оролцуулах тухай

Шаравын Насанжаргалын нэрэмжит “Мэдлэгийн менежмент” улсын X олимпиадад журмын дагуу манай сургуулиас дараах бүрэлдэхүүнтэй багийг оролцуулах хүсэлтэй байна.

Оролцогч багийн хураамж болох 500,000 /таван зуун мянга/ төгрөгийг МУИС Бизнесийн сургууль, ХААН банкны 50 41 12 37 56 тоот дансанд шилжүүлсэн болно.

Шаравын Насанжаргалын нэрэмжит  
“Мэдлэгийн менежмент”-ийн улсын X олимпиадад  
оролцох багийн мэдээлэл

Сургуулийн нэр: /товчлол хэрэглэхгүй/

Сургуулийн нэр, англиар: /товчлол хэрэглэхгүй/

Багийн мэдээлэл

Багийн нэр: .....

	Овог, нэр	Багш бол цол, зэрэг	Суралцаж буй түвшин, курс	Мэргэжил, хөтөлбөр	Е-мэйл хаяг	Утас
Удирдагч багш						
Багийн ахлагч						
Гишүүд						

ЗАХИРАЛ


/

/

**Холбоо барих****Зохион байгуулагч:**

МУИС-ийн Бизнесийн сургуулийн Менежментийн тэнхим

Утас: 77307730-4117, 77307730-4113

**Холбогдох хүмүүс:**

Золзаяа, Менежментийн тэнхимийн туслах ажилтан

e-mail: [zolzaya.p@num.edu.mn](mailto:zolzaya.p@num.edu.mn)

Утас: 91912166

Ө.Зулбаяр, Менежментийн тэнхимийн багш, магистр

e-mail: [zulbayar@num.edu.mn](mailto:zulbayar@num.edu.mn)

Утас: 94182022

Н.Сонинтамир, Менежментийн тэнхимийн профессор, доктор

e-mail: [nsonintamir@num.edu.mn](mailto:nsonintamir@num.edu.mn)

Утас: 99888777